

**БУЛГАН АЙМГИЙН 2024 ОНЫ 11 САРЫН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2024-12-06

Булган

2024 оны 11 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **80,5** тэрбум төгрөг буюу 103,3 хувийн, нийт зарлага **76,2** тэрбум төгрөг буюу 83,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

**1. Төсвийн орлого**

Нийт орлого ба тусламжийн дүн **80,5** тэрбум төгрөг буюу **103.3** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 16,0 тэрбум төгрөг буюу 24,9 хувь, урсгал орлого 12,2 тэрбум төгрөгөөр буюу 26,4 хувиар өссөн байна. Урсгал орлогын гүйцэтгэл **58,8** тэрбум төгрөг буюу **106,9** хувь байна.

(сая төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт /Өмнөх оны мөн үетэй	
		жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5:4)	(5-2)	(5:2)
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>64,492.3</b>	<b>85,899.6</b>	<b>78,001.1</b>	<b>80,549.8</b>	<b>(2,548.7)</b>	<b>103.3</b>	<b>16,057.5</b>	<b>124.9</b>
Урсгал орлого	46,571.4	61,438.9	55,100.1	58,888.7	(3,788.6)	106.9	12,317.3	126.4
Татварын орлого	42,369.4	55,474.3	49,856.6	53,725.4	(3,868.8)	107.8	11,356.0	126.8
Татварын бус орлого	4,202.0	5,934.6	5,221.0	5,099.7	121.3	97.7	897.7	121.4
<b>Хөрөнгийн орлого</b>	<b>33.5</b>	<b>30.0</b>	<b>22.5</b>	<b>63.6</b>	<b>(41.1)</b>	<b>282.7</b>	<b>30.1</b>	<b>189.7</b>
<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын</b>	<b>17,887.4</b>	<b>24,460.7</b>	<b>22,901.0</b>	<b>21,661.2</b>	<b>1,239.8</b>	<b>94.6</b>	<b>3,773.8</b>	<b>121.1</b>
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	8,087.2	14,228.4	12,753.1	11,932.3	820.8	93.6	3,845.1	147.5
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	9,800.2	10,232.3	10,147.9	9,728.8	419.1	95.9	(71.4)	99.3

Нийт орлогын 26,9 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 66,7 хувийг татварын орлого, 6,4 хувийг татварын бус орлого эзэлж байна. Үүнээс ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 27,8 тэрбум төгрөг буюу татварын орлогын 51,7 хувийг бүрдүүлсэн байна.

Сумдын хувьд төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **33,1** тэрбум төгрөг буюу **101,5** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)

д/д	Сумын нэр	2024 он төлөв.	2024 он 11 сар төлөв.	2024 он 11 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	726.2	652.8	590.8	62	90.5
2	Баяннуур	454.1	420.5	457	-36.5	108.7
3	Бугат	554.7	495.3	528.4	-33.1	106.7
4	Булган	8892.4	8136.2	8922.2	-786	109.7
5	Бүрэгхангай	2096.9	1943.1	1681	262.1	86.5
6	Гурванбулаг	511.9	478.8	598.7	-119.9	125.0
7	Дашинчилэн	534.9	495.8	601.5	-105.7	121.3
8	Могод	518.5	468.2	476.4	-8.2	101.8

9	Орхон	926.3	700.2	756	-55.8	108.0
10	Рашаант	1630.4	1456.6	1451.7	4.9	99.7
11	Сайхан	700.6	666.5	777.5	-111	116.7
12	Сэлэнгэ	769.7	704.4	773.4	-69	109.8
13	Тэшиг	1181.2	1038.5	1204.4	-165.9	116.0
14	Хангал	4229.7	3843.4	3878.2	-34.8	100.9
15	Хишиг-Сндер	602.2	546.1	650	-103.9	119.0
16	Хутаг-Сндер	1547.2	1383.6	1444.1	-60.5	104.4
17	Хялганат	766.3	648.4	871.5	-223.1	134.4
	<b>СУМЫН ДҮН</b>	<b>26,643.2</b>	<b>24,078.4</b>	<b>25,662.8</b>	<b>-1584.4</b>	<b>106.6</b>
18	Аймгийн орлого	31,224.3	27,696.1	30,191.8	-2495.7	109.0
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>57,867.5</b>	<b>51,774.5</b>	<b>55,854.6</b>	<b>-4080.1</b>	<b>107.9</b>

Аймгийн дүнгээр авч үзвэл ТТАМАТ, хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр, ой, ан амьтны нөөц ашигласны төлбөр, малд ногдуулах албан татвар, түрээсийн орлого тасарч, бусад татварын орлого биелсэн байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Булган аймагт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гадаад зээлийн эргэн төлөлтийг орон нутгийн өмчит Булган мээж ХХК, Тэшиг ус ХХК-иуд эргэн төлөх чадваргүй байгаагаас зээлийн хүүгийн орлого тасарч байна. Баян-Агт, Бүрэгхангай, Рашаант сумаас бусад сумдын татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна. Эрдэнэс таван толгой ХК-ний хувьцаа эзэмшигч иргэдэд олгосон ногдол ашгийн 10%-ийн орлогын албан татвар орлогын гүйцэтгэлд нөлөөлж байна.

## 2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **76,2** тэрбум төгрөг буюу **83,3** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **68,0** тэрбум төгрөг буюу **82,3** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **8,2** тэрбум төгрөг буюу **92,1** хувь байна.

Аймгийн Авто замын сангийн гүйцэтгэл 1,213.8 сая төгрөг буюу 89,0%, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 3,260.9 сая төгрөг буюу 66,0%, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 5,756.8 сая төгрөг буюу 82,0%, аймгийн Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 6,374.3 сая төгрөг буюу 73,2% байна.

## 3. Төсвийн өглөг, авлага

Нийт өр **40,2** сая төгрөг байна. Нийт өрийн 28,5 сая төгрөг буюу 70,9% нь тогтмол зардлын өр байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС